

Монгол Улс**2014**

Хүн ам, сая хүнээр	3
ДНБ, тэрбум ам.доллар,	12
Нэг хүнд ногдох ДНБ, ам.доллар	4,129
Gini коэффициент, (2007)	0.37
Дундаж наслалт (2013)	67.5

Эх үүсвэр: Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд (WDI), УСХ

Хураангуй

Хөрөнгө оруулалт буурсан, хувийн хэрэглээний өсөлт удааширсан зэрэг нь 2015 онд эдийн засгийн идэвхжил саарахад гол нөлөө үзүүлээ. Ядуурлын түвшин 2014 оны байдлаар 21.6 хувь болж буурсан ч түүний буурах хурдац удаашрав. Шинээр авч буй гадаад зээллэг нь төлбөрийн тэнцэлд ирэх шууд дарамтыг бууруулж, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ыг нэмэгдүүлэхүйц томоохон уул, уурхайн төслийн гэрээ хэлцэл хийгдэв. Гэвч гадаад секторын эмзэг байдал цаашид хэвээр хадгалагдах төлөвтэй байна. Иймд эдийн засгийг эрсдэлээс хамгаалах, гадаад секторын эмзэг байдлыг бууруулах чиглэлд бодлогын дорвитой өөрчлөлт шаардлагатай.

Сүүлийн үеийн эдийн засгийн нөхцөл, байдал

ГШХО татарсан, түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр буурсан орчинд эдийн засгийн бодит өсөлт оны эхний хагаст 3 хувь болж буурсан нь хөрөнгө оруулалт

буурсан болон хэрэглээний өсөлт саарсан зэргээс голлон шалтгаалав. Зэсийн экспортоос шалтгаалан уул, уурхайн салбар 16.5 хувиар өсөв. Бусад салбарын үйлдвэрлэл 0.2 хувиар агшив. ХАА салбар жилийн 9 хувиар өссөн бол худалдаа болон тээврийн салбарууд 7.6 хувь, 4 хувиар тус тус агшчээ. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн салбаруудын идэвхжил харилцан адилгүй байна.

Засгийн газрын албан ёсны ядуурлын шугам болох 146,650 төгрөрөөр тооцсон ядуурлын түвшин 2012 онд 27.4 хувьтай байсан бол 2014 онд 21.6 хувь болж буурсан ч, 2010-12 оны дундажтай харьцуулахад буурах хурдац нь саарчээ. Тухайлбал, хэрэглээний дундаж өсөлт 2012 онд 10.5 хувь байсан бол 2014 онд 2.3 хувь хүрч буурав. ХАА-н салбар бусад салбараас харьцангуй сайн гүйцэтгэлтэй байсанаас ядуурлын түвшин орон нутагт илүү хурдтай буурч байна. Өмнө нь хэрэгжиж байсан хавтгайрсан нийгмийн халамжийн бодлогыг 2013-14 онд хүүхдийн мөнгөний хөтөлбөр болгон өөрчилсөн нь өрхийн орлогод нийгмийн халамжийн үзүүлэх нөлөө буурсан.

Урсгал тэнцлийн алдагдал эхний 7 сарын байдлаар 410 сая ам.доллар болж буурав. Түүхий нефть болон нүүрсний экспорт буурч байгаагаас нийт экспорт жилийн 6.2 хувиар буурлаа. Шатах, тослох материал болон машин тоног төхөөрөмийн импорт буурсан нь нийт импорт жилийн 30 хувиар буурахад голлон нөлөөллөө. Төлбөрийн тэнцэл

эхний 7 сарын байдлаар 82 сая ам.долларын ашигтай гарсан нь ихээхэн хэмжээний гадаад зээлийн санхүүжилттэй холбоотой байв. Эхний 7 сард ГШХО дөнгөж 150 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байсан нь ГШХО-ын орох урсгал сул хэвээр байгааг илтгэж байна. Гэвч багцын хөрөнгө оруулалт 623 сая ам.долларын цэвэр гарах урсгалтай байгаа нь ЗГ-ын болон ЗГ-ын баталгаатай бондуудыг 5, 6 дугаар саруудад гадаад зах зээл дээр гаргасантай холбоотой юм. Энэ нь 4 дүгээр сарын эцэст 1.3 тэрбум ам.доллар байсан гадаад валютын нөөцийг 7 дугаар сард 1.7 тэрбум ам.доллар болж өсөхөд голлон нөлөөлөв. Төвбанк 320 сая ам.долларыг оны эхний 7 сард Хятадын ардын банкнаас своп хэлцлээр авч ашиглажээ. Бүс нутгийн орнуудад сүүлийн үед валютын ханш хэлбэлзэлтэй байгаа ч төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1995 төгрөгт харьцангуй тогтвортой байгаа нь Төвбанкнаас валютын захад хийж буй интервенцтэй холбоотой юм. Улсын инфляцийн түвшин 1 дүгээр сард 9.8 хувь байсан бол 8 дугаар сарын эцэст 6.6 хувь болж буураад байна.

Эхний 7 сард төсвийн орлогын тасалдал 15 хувьд хүрлээ. Орлогын тасалдалтай уялдан төсвийн зардалын гүйцэтгэл төлөвлөгөөний 75 хувьтай байна. Мөнгөний бодлогын төлөв хатуу хэвээр байна. Эдийн засгийн идэвхжил саарч байгаа, Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээл хумигдаж байгаа зэргээс үнэт

цаасжсан орон сууцны зээлийг оруулж тооцсон банкны системийн зээлийн жилийн өсөлт 7 дугаар сарын эцэст 5.5

хувь болж буураад байна. Гэвч Төвбанкнаас санхүүжиж буй орон сууцны зээлийн өсөлт 18 хувьтай байгаа юм. Чанаргүй

зээлийн нийт зээлд эзлэх хувь 2014 оны эцэст 3.1 хувьтай байсан бол 7 дугаар сарын эцэст 5 хувьд хүрчээ.

Эдийн засгийн цаашдын төлөв

Эдийн засгийн бодит өсөлт 2015 оны эцэст 4.4 хувь байхаар өмнө төсөөлөгдөж байсан бол шинэчилсэн төсөөллөөр 3.3 хувь болж буурах урьдчилсан төлөвтэй байна. Уул, уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн идэвхжил буурч байгаагаас уул, уурхайн салбар 2015 оны эцэст 10 хувиар өсч, өсөлт нь саарах төлөвтэй байна. Бусад салбарын өсөлт мөн энэ онд сул хэвээр байх боловч ГШХО-ын сэргэлттэй холбоотойгоор 2016 онд эргэн сэргэх хүлээлттэй байна. Өрхийн бодит орлогын өсөлт удаашралтай байгаа нь ядуурал буурах хурдацыг сааруулж байна. Энэ нь ялангуяа ХАА-аас бусад салбарт ур чадвар бага шаардсан ажлын байрнаас хамааралтай өрхүүдийн хувьд илүүтэй ажиглагдаж байна.

Урсгал тэнцлийн алдагдал энэ онд ДНБ-ий 6-7 хувьд хүрч буурах төсөөлөлтэй байгаа хэдий ч ирэх онд уул, уурхайн салбарын хөрөнгө оруулалтаас хамаарсан импортын өсөлтөөс шалтгаалж эргэн өсөх төлөв ажиглагдаж байна. Оюу Толгойн далд уурхайн төсөл 2016 онд ГШХО-ын орох урсгалыг сэргээж, эдийн засгийн урт хугацааны өсөлтийн төлөвт дэмжлэг үзүүлэхээр хүлээгдэж байна.

Төсвийн цаашдын төлөв сайжрахгүй хэвээр байна. Төсвийн зардлыг орлогын тасалдалтай уялдуулан бууруулахад чиглэсэн төсвийн тодотголыг хийгээгүй тохиолдолд төсвийн алдагдал оны эцэст ДНБ-ий 5 хувиас давах эрсдэлтэй байна. Түүнчлэн Хөгжлийн банкнаас төсвийн гадуур олгож буй арилжааны шинжтэй зээлүүд нь дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн хэрэгжилт болон түүнд итгэх итгэлд сөргөөр нөлөөлж болно.


Эдийн засагт тулгарч буй бэрхшээлүүд

Гадаад секторын хүндрэл, төсвийн орлого их хэмжээгээр тасалдсан, түүхий эдийн үнийн буурсан зэрэг олон сорилтууд Монголын эдийн засагт тулгарсаар байна. Урсгал тэнцлийн алдагдал өсөхөөр байгаа, их хэмжээний хуримтлагдсан гадаад өр 2017 онд эргэн төлөгдөх хуваарьтай зэрэг нь төлбөрийн тэнцлийн хүндрэл үргэлжлэх нөхцлийг бүрдүүлэхээр байна. ГШХО дорвитой сэргэхгүй, уул, уурхайн гол бүтээгдэхүүний үнэ буурсаар байгаа зэрэг нь цаашид эдийн засгийн идэвхжил болон төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Сүүлийн үеийн улс төрийн тогтворгүй байдал үргэлжилсээр байгаа нь сонгуулийн жилд бодлогын дорвитой өөрчлөлт хийхэд саад учруулах эрсдэлтэй.

Эдийн засагт үүсээд буй хүндрэлүүдийг шийдэх чиглэлээр 2015 онд макро эдийн засгийн бодлогуудад зарим тохиргоо хийгдэж байгаа хэдий ч цаашид нэмэлт арга хэмжээ авах, ирээдүйн болзошгүй эрсдэлд бэлтгэх нь чухал юм. 2015 оны төсөвт тодотгол хийх, Хөгжлийн банкны арилжааны шинжтэй зарцуулалтуудад зохистой хяналт тавих нь төсвийн төлөвлөлтийн үр дүн, түүнд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх болно. Төвбанк мөнгөний хатуу бодлогын төлвийг цаашид үргэлжлүүлж, төсвийн шинжтэй хөтөлбөрүүдэд цаашид санхүүжилт олгохоо зогсоох нь зүйтэй.


Ядуурлын шугамтай ойролцоо өрхүүд хувьд эдийн засгийн идэвхжил саарч буй явдал нь тэднийг дахин ядууралд өртөх эрсдлийг нэмэгдүүлж байна. Төсөв, санхүү хүндхэн байгаа өнөөгийн орчинд ядуурлын түвшинг өсгөхгүйн тулд төсвийн зарцуулалтыг ядуурлыг бууруулахад сөрөг нөлөө үзүүлж буй асуудлуудад илүүтэй чиглүүлэх шаардлагатай. Салбарын олон тооны хөтөлбөрүүдийг нэгтгэж, тэдгээрийн зорилтот бүлэг, үр шимийг ядуу, эмзэг бүлэгт илүүтэй чиглүүлэх замаар нийгмийн хамгааллын бодлогыг сайжруулах нь зүйтэй.

Зураг 1. Эдийн засгийн бодит жилийн өсөлтийн задаргаа



Эх үүсвэр: УСХ-ы тоо, мэдээ, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Зураг 2. Өсөлтийн хүртээмжийн мүүрү (Growth incidence curve): 2010–14



Эх үүсвэр: Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Хүснэгт 1. Монгол Улс/Нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд, тэдгээрийн төсөөлөл 2014–17

	2012	2013	2014	2015f	2016f	2017f
Бодит эдийн засгийн өсөлт /Эрэлт талаас тооцсон/	12.3	11.6	7.8	3.3	4.1	4.0
Хувийн хэрэглээ	13.3	14.1	10.6	4.5	7.3	5.8
Засгийн газрын хэрэглээ	18.5	15.2	-1.9	2.4	-0.3	2.3
Үндсэн хөрөнгийн хуримтлал	14.7	-4.3	-33.5	-25.6	32.7	10.9
Экспорт	8.3	13.7	51.4	8.1	5.2	-1.6
Импорт	15.4	6.3	4.9	-3.4	14.2	2.4
Бодит эдийн засгийн өсөлт /Үйлдвэрлэл талаас тооцсон/	12.3	11.6	7.8	3.3	4.1	4.0
Хөдөө, аж, ахуй	21.1	19.3	14.4	9.5	9.0	10.0
Аж үйлдвэр (Уул, уурхайн салбар оруулсан)	14.8	15.3	16.1	7.6	0.7	-0.2
Үйлчилгээ	10.3	6.8	4.8	1.3	5.2	5.6
Инфляци, хугацааны эцэст	14.2	12.3	11.0	7.0	7.8	8.0
Урсгал тэнцэл, ДНБ-д эзлэх хувиар	-27.4	-25.2	-11.7	-6.4	-16.0	-18.5
Төсвийн тэнцэл, ДНБ-д эзлэх хувиар 1/	-9.1	-9.2	-10.8	-8.0	-6.9	-5.5

Эх үүсвэр: УСХ, Сангийн Яам, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн төсөөлөл.

1/ Төсвийн тэнцэлд төсвийн гадуур хэрэгжиж буй ХБ-ны зарцуулалт оруулж тооцсон бөгөөд 10 дугаар сард төсвийн тодотгол батлагдана гэж таамагласан.